

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шивээговь сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2023/27/НА-СТА-ТШЗ

Цахим
хуудас:
www.audit.mn

Говьсүмбэр
аймаг

2023 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543179
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Цахим хаяг: baranbayarg@audit.gov.mn
Аудитор: С.Батцэцэг
Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govsumber@audit.gov.mn

ШИВЭЭГОВЬ СУМЫН "ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР" ЫН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Ч.СУГАРМАА ТАНАА

2023.01.24 № 37
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шивээговь сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Шивээговь сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант хугацаанд няравын хувийн дансаар 10,173.7 мянган төгрөгийн бэлэн мөнгө дамжуулан зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Сумын Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж 31,273.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус зөрчсөн ба нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

008020162

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Шатахууны орлого болон жолоочийн тооцооны хуудсаар тулгалт хийхэд дутуу бичигдсэн, жолоочийн тооцооны хуудасгүйгээр 3,630.7 мянган төгрөгийг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан маягт зааврын НХМаягт ТМ-4 заалтыг тус тус зөрчсөн, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 104 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 86.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	286.8	76.8
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,140.7	1,084.1
	Нийт хөрөнгийн дүн	1,427.5	1,160.9
	Нийт өр төлбөрийн дүн	0.6	0.2
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,426.9	1,160.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,427.5	1,160.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	536.7	832.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	705.6	1,083.0
	Үйл ажиллагааны үр дүн	-168.9	-250.5
	Үйл ажиллагааны бус үр дүн		15.7
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-168.9	-266.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,595.8	1,426.9
	Тайлант оны үр дүн	-168.9	-266.2
	Эцсийн үлдэгдэл	1,426.9	1,160.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	494.7	627.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	493.6	607.9
	Үйл ажиллагааны ЦМГ	1.1	19.2
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	2.6	13.4
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-2.6	-13.4
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-1.5	5.8
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2.3	0.8
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.8	6.5
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	472.3	595.8
	Урсгал зардал	472.3	595.8
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	472.3	595.8
	Улсын төсвийн санхүүжих	472.3	595.8
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	0.00

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шивээговь сумын Засаг даргын тамгын газар нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд оновчтой бодлого төлөвлөлт бүтээмж шинэчлэлд тулгуурласан, иргэнээ дээдэлсэн суралцагч хамт олон байна” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд дэвшүүлсэн зорилтууд

1. “Сумын төвийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн, орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ”
2. “Санхүү, эдийн засгийн нээлттэй ил тод байдлыг хангах бодлого хэрэгжүүлнэ”
3. “Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим орчныг бүрдүүлэн, ил тод байдлыг ханган, иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ”

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 104 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 86 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Ерөнхий Аудиторын орлогчийн 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2022-2023 онд аудитад баримтлах ерөнхий чиглэл”, МУЕА-ын 2022 оны А/89 дүгээр тушаал баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-т тусгасан асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг зөрчил илрээгүй болно.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тухайн байгууллагад онцлох асуудал байхгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- 2022 онд хөрөнгө зарцуулсан 24 тушаалын 39,053.3 мянган төгрөгийн мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим

хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3.2.11 дэх заалтыг зөрчсөн мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Татварын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой тулган баталгаажуулалтаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтын дүнг тулган баталгаажуулаагүй, хяналт тавьж ажиллаагүйгээс 12,315.8 мянган төгрөгийн худалдан авалтыг илүү, дутуу бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж, цахим төлбөрийн баримтад тавих хяналтыг сайжруулж албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

..Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй.....

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 241,395.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс завсрын аудитаар 238,525.9 мянга, аудитын явцад 2,870.0 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- Худалдан авсан 2,870.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ангиллыг буруу тайлагнасныг залруулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 дахь заалтуудыг зөрчсөн мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 59,683.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 4,329.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 55,354.1 мянган төгрөгийн албан шаардлагыг хүргүүлж байна.

7.2 Төлбөрийн акт

7.2.1 Жолоочийн тооцооны хуудсаар шатахуун зарцуулалтыг тулган баталгаажуулахад илүү бичигдсэн болон жолоочийн тооцооны хуудасгүй зэрэг хүчин төгөлдөр бус баримтаар нийт 3,630.7 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Сангийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийг нөхөх заавар НХМаягт ТМ-4” дэх заалтыг тус тус зөрчсөн

7.2.2 “Боржигин түмний дуулал-2022” наадамд оролцсон албан хаагчдад хууль тогтоомжид заагдаагүй 698.3 мянган төгрөгийн урамшууллыг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дах заалтуудыг тус тус зөрчсөн

7.3 Албан шаардлага

7.3.1 Сумын Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж 37,843.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 3.1.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн

7.3.2 Жолоочийн тооцооны хуудсанд гүйцэтгэсэн ажлын тайлан, явсан газрын километр, авто тээврийн хэрэгслийн марк, дугаарыг бүрэн бичээгүй 7,337.2 мянган төгрөгийн зөрчил гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийг нөхөх заавар НХМаягт ТМ-4” дэх заалтыг тус тус зөрчсөн

7.3.3 Няравын хувийн дансаар дамжуулан уралдаан тэмцээний шагналын мөнгө болох нийт 10,173.9 мянган төгрөгийн бэлэн мөнгө гаргаж зарцуулсан ба хувь хүмүүсийн дансыг авч шилжүүлээгүй зөрчил гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5 дах заалтыг тус тус зөрчсөн

7.4 Зөвлөмж

1. Цалин хөлс тайлагнахтай холбоотой

1.1. Илрүүлэлт:

Хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хувь хүнд олгосон цалин, хөлсийг ХХОАТ-ын тайланд тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах байгаа албан хаагчдын цалин, хөлсийг хууль тогтоомжид заасны дагуу бүрэн тайлагнаж байх

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг хугацаанд нь гаргаж, зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 25-ны дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

8 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	11	532.4	5	241.4	2	4.3	3	55.3		
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	11	532.4	5	241.4	2	4.3	3	55.3		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ							2	51.4	1	-
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн										
	НИЙТ ДҮН							2	51.4	1	-